



247

БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 5 сарын 18

№62

Улаанбаатар
хот

**Сургалтын төв байгуулах
тухай**

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 402 дугаар тогтоол, БНМАУ-ын Зөвсөгт хүчний жанжин штабын хүсэлтийг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Ерөнхий боловсролын дунд сургуулийн 8,10 дугаар анги төгсөгчдөд мэргэжил эзэмшүүлэх БНМАУ-ын Зөвсөгт хүчинд шаардагдах авто машины жолооч нарыг бэлтгэх, цэргийн өмнөх насны залуучууд, ард иргэдийн иргэний хамгаалалтын сургалт явуулах зорилгоор Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны Цэрэг, иргэний хамгаалалтын газрын харьяанд сургалтын төвийг аж ахуйн тооцооны үндсэн дээр байгуулж ажиллуулсугай.

2. Шинээр байгуулагдаж байгаа сургалтын төвд сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж бэлтгэх, эд хогшил худалдан авч сургалт явуулах боломж бүрдүүлэхэд нь зориулж 500 мянга хүртэл төгрөгийг жижиг үйлдвэр байгуулах, ажлын байр бий болгох сангаас нэг удаа олгохыг Санхүүгийн газар /н.Гонгор/-т зөвшөөрсүгэй.

3. Тус төвд эхний ээлжинд авто машины жолооч слесарь, цахилгаанчны мэргэжлээр 800 хүнийг 2 ээлжээр 5 сарын хугацаатай суралцуулахыг Цэрэг, иргэний хамгаалалтын газар /н.Доржсүрэн/-д даалгасугай.

4. Тус курст ерөнхий боловсролын дунд сургуулийн 8,10 дугаар анги төгсөгчдөөс элсүүлэн суралцуулж сургалтын зардалд хүн бүрд 4000 хүртэл төгрөгийг мэргэжил эзэмших, ажлын байр бий болгох зардлаас тооцож олгохыг Хөдөлмөр, нийгэм хангамжийн хэлтэс /н.Чинбат/-д зөвшөөрсүгэй.

5. Хүн амын төрөл бүрийн үйлчилгээг хөгжүүлэхтэй холбогдуулан хотод шаардагдах мэргэжилтэй ажилчдыг хөдөлмөрийн хоршоолол, үйлдвэр, аж ахуй үйлчилгээний байгууллагын захиалгаар тус

2..

төвд сурган бэлтгэж байхыг Хөдөлмөр, нийгэм хангамжийн хэлтэс /н.Чинбат/-д даалгасугай.

6.Сургалтын төвийн орон тоо зохион байгуулалт сургалт хүмүүжлийн нэгдсэн бодлого боловсруулах, сургалтын техник хэрэгсэл, материаллаг бааз, хангалтын асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж 1991-1992 оны хичээлийн жилд сургалтыг эхлүүлэхийг Цэрэг, иргэний хамгаалалтын газар /н.Доржсүрэн/, Хөдөлмөр, нийгэм хангамжийн хэлтэс /н.Чинбат/, Материал хангамжийн хэлтэс /н.Жигжидсүрэн/, Замын цагдаагийн газар /н.Занашир/ нарт даалгасугай.

7.Сургалтын төвд зориулж Зөвлөлтийн байгууллагаас монголын талд шилжүүлэн өгч байгаа сургуулийн барилгаас нэгийг хуваарилж өгөхийг Өмчийн газар /н.Найдан/-д зөвшөөрсүгэй.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУМҮҮЖЛИЙН ГҮМЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Ч.СУМААХҮҮ